



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/652

Хэрлэн сум

Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 24 дүгээр “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам батлах тухай” тогтоол, 2023 оны хорин гуравдугаар хуралдааны 02 дугаар “Журамд өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2024 оны хорин долоодугаар хуралдааны 08 дугаар “Аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зөгийн үүр” арга хэмжээний хүрээнд “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2024-2025 оны хичээлийн жилд орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж буй нэр бүхий оюутнуудад сургалтын төлбөрийн 5,150,000 (таван сая нэг зуун тавин мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй

2. Суралцагчдын төлбөрийн мэдээллийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад дэмжлэг үзүүлнэ” зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 10 -ний өдрийн
11652 дугаар захирамжийн хавсралт

СУРАЛЦАГЧДЫН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Суралцагчийн овог, нэр	Харьяалал	Эзэмшиж буй мэргэжил	Курс	Суралцаж буй сургуулийн нэр	Төлбөрийн хэмжээ
1	Батбилэг Саранцэцэг	Цэнхэрмандал сум	Хүний их эмч	6	ИЗОУИС	3,200,000
2	Наянтай Гэрэлтуяа	Дэлгэрхаан сум Хэрлэнбаян-Улаан тосгон	Хүний их эмч	5	Глобаль удирдагч дээд сургууль	1,950,000
	нийт					5,150,000